Хаяг:Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй Дүүрэг,6 -р хороо, Ялалт плаза 8 давхар 804 тоот

Утас: +976-89135533

И-мэйл: softmaster.aagii@gmail.com

# УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ, ВЕБ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ E-MONGOLIA ПЛАТФОРМД ХОЛБОХ АЖЛЫН ЭЦСИЙН ТАЙЛАН

| | |
|---|---|
| Захиалагч: | -БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,<br>ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР<br>-БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН НЭГЖ |
| Гүйцэтгэгч: | “Софт Мастер” ХХК |
| Огноо: | 2021 оны 11-р сарын 03 –ны өдөр |

Улаанбаатар 2021

# УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАХ, ВЕБ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ E-MONGOLIA ПЛАТФОРМД ХОЛБОХ АЖЛЫН ЭЦСИЙН ТАЙЛАН

**ЗАХИАЛАГЧ**

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН НЭГЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР**

Монгол улс, Улаанбаатар - 15160, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр

Утас: +976-51 267283

И-мэйл: info@mpa.gov.mn

**ГҮЙЦЭТГЭГЧ**

**“СОФТМАСТЕР” ХХК**

Захирал Б.Анхболд

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй Дүүрэг,6 -р хороо, Ялалт плаза 8 давхар 804 тоот

Утас: +976-89135533

И-мэйл: softmaster.aagii@gmail.com

# 1. Агуулга


1. Агуулга .......... 2

2. Ерөнхий хэсэг .......... 5

2.1. Оршил .......... 5

2.2. Хамрах хүрээ .......... 6

3. Газрын кадастрын лэнд менежер программ хангамжийг хөгжүүлэх .......... 6

3.1. Хэрэглэгчийн удирдлага .......... 6

3.2. Тохиргоо .......... 7

3.2.1 Тусгай хэрэгцээний газрын мэдээллийг засварлах .......... 7

3.2.2 Тусгай хамгаалалттай газрын бүсийн дэглэм .......... 8

3.3. Газар ашиглах боломжгүй хамгаалалтын хамгаалалтын болон бусад бүсүүдтэй шалгах .......... 8

3.4. Өргөдөл буюу газар ашиглах хүсэлт .......... 9

3.5. Баримт бичгийн бүрдэл, хавсралт материал .......... 11

3.6. Сайдын төсөл ба шийдвэр .......... 13

3.7. Газар ашиглах гэрээ .......... 15

4. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн цахимаар авах .......... 18

4.1. Газар ашиглах цахим хүсэлт .......... 18

4.2. Цахим хүсэлт шалгах .......... 20

5. Гар утасны хөгжүүлэх .......... 23

5.1. Гар утсаар газрын цахим хүсэлт гаргах .......... 23

5.2. Өргөдлийн төрөл тус бүрт шаардлагатай хавсралт оруулах тохиргоо ...... 24

5.3. Цахимаар өргөдөл шалгах ...... 26

5.4. Газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн хувийн хэргийн мэдээллийг системд бүртгэх ...... 29

6. Нэмэлт хөгжүүлэлт ...... 30

6.1.1. Ажлын урсгалыг төлөв ...... 33

6.1.2. Ажлын урсгал ...... 34

6.2.1. Улсын тэмдэгтийн хураамжийн бүртгэл /Үйлчилгээний төрөл/ ...... 37

6.2.2. Өргөдөлд тэмдэгтийн хураамж холбох ...... 39

6.3.1. Ашиглаж буй газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт хэвлэх ...... 41

6.3.2. Ашиглаж буй газрын хянан баталгааны мэдэгдэх хуудас хэвлэх ...... 42

6.3.3. Ашиглаж буй газрын хянан баталгааны дүгнэлт хэвлэх ...... 42

***Зургийн дугаарлалт***

Зураг 1. Тусгай хэрэгцээний газрын жагсаалт ........ 6
Зураг 2. Тусгай хэрэгцээний газрын дэглэмийн жагсаалт ........ 7
Зураг 3. Тусгай хэрэгцээний газрын давхцал шалгах ........ 7
Зураг 4. Хүсэлтийн жагсаалт ........ 8
Зураг 5. Хүсэлтийн цэс ........ 9
Зураг 6. Хүсэлтийн дэлгэрэнгүй ........ 10
Зураг 7. Хавсралтын төрлийн жагсаалт ........ 11
Зураг 8. Хавсралтын төрөл холбох ........ 11
Зураг 9. Сайдын тушаал бэлтгэх ........ 12
Зураг 10. Шийдвэрийн төслийн өргөдөл ........ 13
Зураг 11. Шийдвэрийн өргөдөл ........ 13
Зураг 12. Нэмэлт нөхцөл ........ 14
Зураг 13. Нэмэлт нөхцөл оруулах ........ 14
Зураг 14. Гэрээ цуцлах ........ 15
Зураг 15. Хүсэлт гаргах төрөл ........ 17
Зураг 16. Хүсэлт гаргах ........ 17
Зураг 17. Тусгай хамгаалалттай газрын дэлгэрэнгүй ........ 18
Зураг 18. Хүсэлтийн жагсаалт ........ 19
Зураг 19. Хүсэлтийн дэлгэрэнгүй ........ 19
Зураг 20. Тусгай хамгаалалттай газрын хилийн мэдээлэл ........ 20
Зураг 21. Тусгай хамгаалалттай газрын бүсийн мэдээлэл ........ 20
Зураг 22. Өргөдлийг цахимаар авах ........ 22
Зураг 23. Өргөдлийг цахимаар авах тохиргоо ........ 23
Зураг 24. Хавсралт материал оруулах ........ 24
Зураг 25. Хавсралтын төрөл цахимаар авах тохиргоо ........ 25
Зураг 26. Миний өргөдөл харагдах хэсэг ........ 26
Зураг 27. Өргөдлийн дэлгэрэнгүй мэдээлэл ........ 27
Зураг 28. Өргөдөл хайх ........ 28
Зураг 29. Иргэн хуулийн этгээд бүртгэх ........ 29
Зураг 30. Хуулийн этгээд нэвтрэх ........ 30
Зураг 31. Тоон гарын үсгээр нэвтрэх ........ 31
Зураг 32. Ажлын урсгалын төлөв ........ 32
Зураг 33. Ажлын урсгал ........ 33
Зураг 34. Ажлын урсгалын ерөнхий мэдээлэл ........ 34
Зураг 35. Ажлын урсгалын төлөв ........ 34
Зураг 36. Ажлын урсгалын төлөв нэмэх ........ 35
Зураг 37. Ажлын урсгалын өргөдөл ........ 36
Зураг 38. Ажлын урсгалын дагуу шийдвэрлэгдэж буй өргөдөл ........ 37

Зураг 39. Үйлчилгээний төрөл ... 38
Зураг 40. Үйлчилгээний төрөл нэмэх ... 39
Зураг 41. Үйлчилгээний хураамж нэмэх ... 40
Зураг 42. Үйлчилгээний хураамжийн жагсаалт ... 40
Зураг 43. Тооцоо нийлсэн акт хэвлэх ... 41
Зураг 44. Мэдэгдэх хуудас ... 42
Зураг 45. Дүгнэлт хэвлэх ... 43

***Нэр томьёоны тайлбар***

| | |
|---|---|
| ГКМС | Газрын кадастрын мэдээллийн сан |
| ГЗБТ | Газар зохион байгуулалтын төлөвлөгөө |
| UTM | Universal Transverse Mercator- Дэлхийн хөндлөн меркаторын тусгаг |
| WGS-84 | World Geodetic System- Дэлхий нийтийн геодезийн систем буюу эллипсиод юм |
| ГХГЗЗГ | Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газар |
| БОАЖЯам | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| ГНУСистем | Газрын нэгдсэн удирдлагын систем |
| ГНС | Газрын нэгдмэл сан |
| ТХГН | Тусгай хамгаалалттай газар нутаг |

# 2. Ерөнхий хэсэг

## 2.1. Оршил

Монгол улсын нутаг дэвсгэр дээрх эрхийн харилцаа үүссэн нийт газрыг бүртгэж, эрх зүйн харилцааны үйл ажиллагааг удирдах газрын кадастрын нэгдсэн

систем/Лэнд Менежер/ 2015 оноос 21 аймаг, 330 сум, нийслэл, 9 дүүрэгт нэвтрэн ажиллаж байгаа юм.

Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглуулж байгаа газар нь тус мэдээллийн санд хамаарах өгөгдлийн бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд тус мэдээллийн санд бүртгэгдэх шаардлагатай юм. Тусгай хамгаалалтай газрын тухай хууль болон газрын кадастрын тухай хуулийг баримтлан тус мэдээллийн санд бүртгэх бүрэн боломжтой юм.

Газрын кадастрын мэдээллийн удирдлагын системээр дамжуулан тусгай хамгаалалттай нутагт газар ашиглуулах эрхийн эрх зүйн баримт бичиг болон үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэж байна.

### 2.2. Хамрах хүрээ

Улсын хэмжээний нийт тусгай хамгаалалттай газар нутгийн зааг болон хамгаалалт, хязгаарлалтын бүсийн хил, заагийн хүрээнд орон зай нь хамаарна.

Хэрэглэгчийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн болон бусад хамгаалалтын захиргаадын мэргэжилтэн байна.

Газрын удирдлагын системийн өгөгдлийн санд суурилсан газрын кадастрын системд эрхийн хүрээнд олгогдсон үйлдлийг өөрийн хариуцсан тусгай хамгаалалттай газар нутагт гүйцэтгэж ажиллана.

## 3. Газрын кадастрын лэнд менежер программ хангамжийг хөгжүүлэх

### 3.1. Хэрэглэгчийн удирдлага

Улсын хэмжээнд 21 аймаг 330 сум болон нийслэл, дүүрэг ашиглаж байгаа газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд Менежер программ хангамжийг ТХГН-н хамгаалалтын захиргаадын мэргэжилтнүүд ашиглахын тулд эхлээд хэрэглэгчийн удирдлагад өөрчлөлт оруулах шаардлагатай.

Хэрэглэгчийн удирдлагын бүртгэлд мэргэжилтэнг бүртгэхдээ тухайн ажилтны иргэний мэдээллийг бүртгээд тухайн иргэний мэдээллийг ашиглан ажилтан болгон системд бүртгэнэ. Системд ажилтнаар бүртгэхдээ БОАЖЯам-г сонгоно дараа нь ажиллах засаг захиргааны нэгж болон эрхийн сонголтыг хийнэ. Мөн харьяалагдах

хэлтэс болон албан тушаалыг заавал сонгож өгнө. Сонгогдсон засаг захиргаа болон албан тушаалаас хамааран ажиллах эрх өөр өөр байж болно. Ажилтны тохиргоог хийж дууссаны дараагаар системд нэвтрэх хэрэглэгчийн эрхийг нэмж өгөх юм.

Хэрэглэгчийг бүртгэснээр программ хангамж дээр ажиллах эрх нээгдэнэ. Системийн админ эрхтэй хэрэглэгч эрхийн тохиргоог хийнэ.

## 3.2. Тохиргоо

Тохиргооны хэсэгт админ эрхтэй хэрэглэгч хийж гүйцэтгэх эрхтэй байх ба уг хэсэгт тусгай хэрэгцээний газрын мэдээллийг засварлах үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

### 3.2.1 Тусгай хэрэгцээний газрын мэдээллийг засварлах

Энэ тохиргоо нь тусгай хэрэгцээний газрыг харьяа хэлтэст хамааруулан холбож өгөх болон тухайн газрын мэдээллийг засварлах үйлдлүүдийг хийж гүйцэтгэнэ. Энэхүү тохиргоог хийснээр тухайн тусгай хэрэгцээний газар нутагт газар ашиглах хүсэлт ирэхэд тохиргооны дагуу тухайн харьяа хэлтэст автоматаар хуваарилагдах боломж бүрдэх юм.




*Зураг 1. Тусгай хэрэгцээний газрын жагсаалт*

### 3.2.2 Тусгай хамгаалалттай газрын бүсийн дэглэм

Энэ тохиргоо нь тусгай хамгаалалттай газрын мэдээллийг засварлах болон тухайн газарт газар ашиглах тохиолдолд зөвшөөрөгдөх болон хориглох дэглэмүүдийг тодорхойлж өгдөг тохиргооны хэсэг юм. Ингэснээр тухайн тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох боломжтой болох ба зөвшөөрөгдөх болон хориглогдох дэглэмүүдийг хэрэглэгчдэд хүргэх боломж нь бүрдэх юм.




*Зураг 2. Тусгай хамгаалалттай газрын дэглэмийн жагсаалт*

## 3.3. Газар ашиглах боломжгүй хамгаалалтын хамгаалалтын болон бусад бүсүүдтэй шалгах

Тусгай хэрэгцээний газар нутагт газар ашиглах хүсэлтийг egazar.gov.mn сайтаар хүлээн авах боломжтой болсон. Шинээр ашиглах хүсэлт гаргах болон бусад газрын мэдээллийг шинэчлэх хүсэлтүүдийг хүлээн авахдаа ус, ой, зам, шугам сүлжээ буюу нэгдмэл сангийн бүртгэл, тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэл, улсын онцгой объект буюу маш нууц зэрэглэлтэй газар зэрэг газруудтай давхардлыг шалгах шаардлагатай юм. Бид уг шаардлагын дагуу хүсэлт гаргаж буй газрын

байршлыг бусад хориглогдсон газруудтай давхардаг буй эсэх, хамгаалалтын зурвасыг давсан эсэхийг шалгах тохиргоог хийж гүйцэтгэсэн.




*Зураг 3. Давхцал шалгах*

Зурагд харагдаж байгаагаар тухайн хүсэлт гаргаж буй газрын байршлыг оруулахад бусад онцгойлсон шаардлага бүхий газрын хилүүдтэй давхардал шалгаж тухайн байршилд газар ашиглах боломжтой эсэхийг системээс харуулдаг болсон.

## 3.4. Өргөдөл буюу газар ашиглах хүсэлт

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргасны дараагаар уг хүсэлтийг тухайн тусгай хамгаалалттай газар нутгаасаа хамаараад харьяа хэлтэстээ харагдах ба тухайн хэлтсийн ажилтан нь уг хүсэлтийн хүлээн авч өргөдөл үүсгэн цааш шийдвэрлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

Захиалагчийн шаардлагын дагуу дараах өргөдлийн төрлүүдийг нэмж хөгжүүлсэн бөгөөд шаардлагатай засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэлээ.

- ТХГН-т шинээр газар ашиглуулах
- Газар ашиглах эрхийн гэрчилгээ сунгах
- Талбайн хэмжээ өөрчлөх
- Газар ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах
- Өөрийн хүсэлтээр эрхээс татгалзах
- Шүүхийн шийдвэрээр цуцлах/сэргээх




*Зураг 4. Хүсэлт хүлээн жагсаалт*

БОАЖЯам-ны харьяа хэлтэс байгууллагын ажилтан нь хэрэглэгчийн эрхээрээ системд нэвтрэхэд хариуцсан газар нутагт газар ашиглахтай холбоотойгоор өргөдөл цахимаар ирсэн бол тухайн шинээр ирсэн хүсэлтүүдийн тоог улаан өнгөөр тодруулан харуулдаг ба тухайн ажилтан жагсаалт хэсгээс шинээр нэмэгдсэн хүсэлтүүдийн дэлгэрэнгүй хэсэгрүү орж хүсэлтийн хүлээн авах өргөдөл үүсгэх үйлдлийг хийж гүйцэтгэнэ.




*Зураг 5. Хүсэлтийн цэс*

Хүсэлтийн дэлгэрэнгүй хэсэг нь тухайн хүсэлтийн мэдээллийг харуулах ба дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ерөнхий мэдээлэл
  Хүсэлтийн ерөнхий мэдээллүүд болох хүсэлт гаргагч, хүсэлт гаргасан төрөл, давхаргын төрөл, тухайн хүсэлтийн төлөв болон уг хүсэлтийн дагуу өргөдөл үүссэн бол өргөдлийн дугаарыг харуулна.

- Хавсралт
  Хүсэлтийг гаргахад шаардлагатай хавсралтууд болон нэмэлтээр оруулсан хавсралт материалуудын жагсаалт харагдана. Жишээ: Өргөдөл, иргэний үнэмлэх, аж ахуйн нэгжийн гэрчилгээ гэх мэт
- Нэгж талбар
  Хүсэлт гаргаж буй газрын байршил болон тухайн газрын талбай, зориулалт, хаягийн мэдээллийг харуулна
- Төлөв
  Хүсэлтийн мэдээллүүдийг шалгасны дараагаад хүсэлтийг хүчингүй болгох эсвэл зөвшөөрч цааш өргөдөл үүсгэн шийдвэрлүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэдэг хэсэг




*Зураг 6. Хүсэлтийн дэлгэрэнгүй*

## 3.5. Баримт бичгийн бүрдэл, хавсралт материал

Цахимаар хүсэлт гаргагч нь хүсэлт гаргахад хавсралт материалыг оруулах боломжтойгоор хөгжүүлэлт хийгдсэн. Гаргаж буй хүсэлтийн төрлөөс шалтгаалан хавсралт материалыг хүсэлт гаргахад заавал авах, заавал бусаар хавсаргах боломжтойгоор тохируулах хэсгийг админ хэрэглэгч хийх боломжийг бүрдүүлсэн.

Хавсралтын тохиргоог хийхдээ эхлээд хавсралтын төрлийн тохиргоог хийнэ.

Хавсралтын тохиргоо нь дараах мэдээллүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Код
  Хавсралтын төрлийн давтагдахгүй дугаар
- Нэр
  Хавсралтын төрлийн нэршил
- Төрөл
  Хавсралтын төрлийн зориулагдсан модулийн төрөл. Гэрээ, өмчлөл, өргөдөл

гэх мэт

- Дараалал
  Хавсралтын харагдах байдлын дараалын утга
- Анх бүртгэхэд заавал авах эсэх
  Тухайн хавсралтыг заавал авах эсэхийг тодорхойлно
- Цахим хүсэлтээр авах эсэх
  Тухайн хавсралтын төрлийг цахим хүсэлтээр авах эсэхийг тодорхойлно
- Дугаар авахад заавал илгээх
  УБЕГ-рүү илгээхэд заавал шаардагдах эсэхийг тодорхойлно
- Дугаар авсны дараа заавал илгээх
  УБЕГ-с дугаар авсны дараа буцаан илгээхэд заавал шаардах эсэхийг тодорхойлно




| No. | Код | Нэр | Анх бүртгэхэд заавал оруулах | Дугаар авахад заавал илгээх | Дугаар авсны дараа заавал илгээх | Цахим хүсэлтээр авах | Төрөл | Дараалал | Удирдах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | Өргөдөл | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Өргөдөл | | |
| 2 | 2 | Иргэний үнэмлэх, аж ахуйн нэгжийн гэрчилгээ | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Өргөдөл | | |
| 3 | 3 | Тухайн газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал | Үгүй | Тийм | Үгүй | Үгүй | Өргөдөл,Гэрээ,Өмчлөл | | |
| 4 | 4 | Хүсэлт гаргасан газрын тойм зураг | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Өргөдөл | | |
| 5 | 5 | Дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтын материал | Тийм | Үгүй | Үгүй | Үгүй | Өргөдөл | | |
| 6 | 6 | Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн иргэний үнэмлэх | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Өргөдөл | | |

*Зураг 7. Хавсралтын төрлийн жагсаалт*

Хавсралтын төрлийн мэдээллийг тохируулсны дараа тухайн хавсралтын төрлийг дурын өргөдлийн төрөлд ашиглах боломжтой ба хэдэн ч өргөдлийн төрөлтэй холбогдон тохиргооны дагуу ашиглагдах боломжтой юм. Өргөдөлтэй холбогдсон хавсралтын төрөл нь өргөдлийн төрөл модулийн дэлгэрэнгүй хэсэгт “Хавсралтын төрөл” хэсэгт харагдана. Энэ хэсэгт шинээр хавсралтын төрөл холбох болон хавсралтын төрлийг хасах үйлдлийг хийж гүйцэтгэх боломжтой.




*Зураг 8. Хавсралтын төрөл холбох*

## 3.6. Сайдын төсөл ба шийдвэр

Цахим хүсэлтийн дагуу өргөдөл үүссэний дараагаар тухайн өргөдлийг шийдвэрлэх явц шийдвэрийн төсөл буюу сайдын төслийг үүсгэнэ. Ингэснээр тухайн өргөдөл шийдвэрлэгдэх боломжтой болох юм.

Шийдвэрийн төсөл буюу сайдын төслийн тухайн орон нутгийг хариуцсан мэргэжилтэн бүртгэх бөгөөд уг төсөл нь зөвхөн БОАЖЯамны ажилчдад харагдах юм.

Шийдвэрийн төсөл үүсгэхдээ тухайн төслийн төрөл, шийдвэрийн төслийн хугацаа болон шийдвэрийн төсөлд орох өргөдлийн тоо хэмжээг тодорхойлох боломжтой.




*Зураг 9. Сайдын тушаал бэлтгэх*

Шийдвэрийн төсөл буюу сайдын төслийг үүсгэсний дараа тухайн төсөлд хамаарагдах өргөдлүүдийг холбох үйл ажиллагаа хийгдэнэ.




*Зураг 10. Шийдвэрийн төслийн өргөдөл*

Бүх өргөдлүүдийг төсөлтэй холбож дуусаад шийдвэрийн бүртгэл үүсгэх ба уг төсөл дээр үндэслэн шийдвэр бүртгэгдсэнээр төсөлд холбоотой өргөдлүүдийн шийдвэр гарах юм.

Шийдвэрийн төслийн дагуу шийдвэр бүртгэхэд шийдвэрийн дэлгэрэнгүй хэсэгт төсөлд холбогдсон өргөдлүүд харагдах ба шийдвэрийн хэсэгт өргөдлийг зөвшөөрч

шийдвэр гарах болон өргөдлийн зөвшөөрөхгүйгээр дуусгавар болгох үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Шийдвэртэй холбоотой өргөдлүүдэд шийдвэр гарсан тохиолдолд цааш гэрээ үүсэж гэрчилгээ олгогдох боломжтой болох юм.




*Зураг 11. Шийдвэрийн өргөдөл*

## 3.7. Газар ашиглах гэрээ

Шийдвэр гарсан тохиолдолд тухайн хүсэлтийн дагуу өргөдөл дээр гэрээ үүсэх боломжтой болох юм. Гэрээг үүсгэхдээ хүсэлтийн дагуу үүссэн өргөдлийг ашиглан үүсгэнэ.

Гэрээг үүсгэхэд гэрээ эхлэх болон дуусах огноо, гэрээний төрлийг зааж өгөх ба бусад мэдээллүүд өргөдлөөр дамжин татагдах юм.

Захиалагчийн хүсэлтийн дагуу нэмэлт нөхцөл оруулах боломжтой болсон ба энэ хэсэг нь гэрээний дэлгэнгүй хэсэгт “Нэмэлт нөхцөл” талбар хийгдэнэ.



*Зураг 12. Нэмэлт нөхцөл*

Тухайн газар ашиглах хүсэлт болон бусад мэдээлэл дээр үндэслэн гэрээн нэмэлт нөхцөл оруулах боломжтой ба шинээр нэмэх товчийг дарснаар боломжит нэмэлт нөхцөлүүдээс сонгон гэрээнд нэмэлт нөхцөлийг нэмэх юм.




| No. | Код | Нэмэлт заалт | Эрэмбэ |
|---|---|---|---|
| 1 | 1306001 | Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах, | |
| 2 | 1306002 | Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, түүнд үндэслэсэн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүгнүүлнэ | |
| 3 | 1306100 | Хадлангийн газар | |
| 4 | 1306101 | Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно, | |
| 5 | 1306102 | хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлэх арга хэмжээ авах, | |
| 6 | 1306200 | Хот суурингийн газарт | |
| 7 | 1306201 | Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын | |

*Зураг 13. Нэмэлт нөхцөл оруулах*

Гэрээнд нэмэлтээр оруулсан нэмэлт нөхцөлүүд нь уг гэрээг хэвлэх үйлдэл хийгдэхэд батлагдсан загварын дагуу хэвлэгдэх гурвалсан гэрээний нөхцөл хэсэгт бичигдэж хэвлэгдэнэ.

Газар ашиглах гэрээг цуцлах үед мөн нэмэлт нөхцөл оруулах боломжийг бүрдүүлсэн ба гэрээг цуцлах үед цуцлах үндэслэл болон цуцалсан шийдвэрийн дугаар огноо зэрэг мэдээллийг оруулах боломжтой.




*Зураг 14. Гэрээ цуцлах*

Гэрээ үүссэн тохиолдолд газрын төлбөр бодуулах боломжтой болох ба төлбөрийг системд буй аргачлал үнэлгээний дагуу автоматаар бодох юм.

Төлбөр бодуулсны дараагаар төлбөрийн нэхэмжлэх болон төлбөртэй холбоотой бусад тайлан мэдээлэл хэвлэх боломжтой.

Бид захиалагчийн хүсэлтийн дагуу хэрэглэгчид систем хэрэглэхэд хялбар байх үүднээс хэрэглэгч нэвтрэх үед тухайн хэрэглэгчийн харьяа хэлтэс байгууллагаас хамааран гэрээ болон өргөдөл, шийдвэр, шийдвэрийн төслийн жагсаалтуудыг зөвхөн өөрт хамааралтайг харуулдаг байдлаар тохиргоо нэмж хийсэн.

# 4. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглах эрхтэй холбоотой өргөдлийн цахимаар авах

## 4.1. Газар ашиглах цахим хүсэлт

Тусгай хэрэгцээний газар нутагт газар ашиглах хүсэлтийг egazar.gov.mn сайтаар хүлээн авах боломжтойгоор хөгжүүлэлт хийгдсэн ба хүсэлт гаргагч нь ДАН бүртгэлийн системээр дамжин иргэний мэдээллээ ашиглах egazar.gov.mn сайтруу нэвтрэх юм. Нэвтэрснээр тухайн иргэн дараах төрлүүдээр цахимаар хүсэлт гаргах боломжтой болсон. Үүнд:

- ТХГН-т шинээр газар ашиглуулах
- Газар ашиглах эрхийн гэрчилгээ сунгах
- Талбайн хэмжээ өөрчлөх
- Газар ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах
- Өөрийн хүсэлтээр эрхээс татгалзах
- Шүүхийн шийдвэрээр цуцлах/сэргээх

Хүсэлтийн төрлөөс хамааран оруулах мэдээллүүд өөр өөр байна. Жишээ нь: Шүүхийн шийдвэрээр эрх цуцлах үед цуцалсан хугацаа болон огноо, шүүхийн шийдвэрийн баримтыг цахим архивын хэсэгт оруулах гэх мэт.




*Зураг 15. Хүсэлт гаргах төрөл*




*Зураг 16. Хүсэлт гаргах*

Цахимаар хүсэлт гаргахад шинээр ашиглах хүсэлт гаргах болон бусад газрын мэдээллийг шинэчлэх хүсэлтүүдийг хүлээн авахдаа ус, ой, зам, шугам сүлжээ буюу нэгдмэл сангийн бүртгэл, тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэл,

улсын онцгой объект буюу маш нууц зэрэглэлтэй газар зэрэг газруудтай давхардлыг шалгах шаардлагатай юм. Бид уг шаардлагын дагуу хүсэлт гаргаж буй газрын байршлыг бусад хориглогдсон газруудтай давхардаг буй эсэх, хамгаалалтын зурвасыг давсан эсэхийг шалгах тохиргоог хийж гүйцэтгэсэн.

Ингэснээр газар ашиглах боломжгүй байршилтай бол улаан өнгөөр анхааруулах зурвас харуулж газар ашиглах боломжтой үед тухайн давхардаж буй тусгай хамгаалалттай газрын байршлын мэдээлэл болон хориглох, зөвшөөрөх дэглэмийг харуулах юм.




*Зураг 17. Тусгай хамгаалалттай гарын дэлгэрэнгүй*

## 4.2. Цахим хүсэлт шалгах

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргасны дараа тухайн хүсэлт гаргасан хүний иргэний мэдээлэл дээр тулгуурлан бүртгэл үүссэн байх бөгөөд өөрийн гаргасан цахим хүсэлтийн жагсаалтыг шийдвэрлэлтийн явцын хамт харах боломжтой.




*Зураг 18. Хүсэлтийн жагсаалт*

Дэлгэрэнгүй хэсэгт тухайн хүсэлтийн өргөдөл үүссэн эсэх болон өргөдөл үүссэн тохиолдолд ямар явцтай шийдвэрлэгдэж байгаа мөн гэрээ гэрчилгээ төлбөрийн мэдээллийг дэлгэрэнгүй харах боломжтой.




*Зураг 19. Хүсэлтийн дэлгэрэнгүй*

ТХГН-н хил заагийн болон бусад нээлттэй мэдээллийг газрын кадастрын олон нийтэд нээлттэй мэдээллийн сайт болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) дээр нэмэлт хардаг болгосон. Ингэснээр хаана ямар байршилтай тусгай хамгаалалттай газар байгаа болон тэдгээрийн зөвшөөрөгдөх болон хориглох дэглэмийн мэдээллийг дэлгэнгүй харах боломжтой юм.




*Зураг 20. Тусгай хамгаалалттай газрын хилийн мэдээлэл*




*Зураг 21. Тусгай хамгаалалттай газрын бүсийн мэдээлэл*

# 5. Гар утасны хөгжүүлэх

## 5.1. Гар утсаар газрын цахим хүсэлт гаргах

Тусгай хэрэгцээний газар нутагт газар ашиглах хүсэлтийг egazar гар утасны программаар хүлээн авах боломжтойгоор хөгжүүлэлт хийгдсэн ба хүсэлт гаргагч нь ДАН бүртгэлийн системээр дамжин иргэний мэдээллээ ашиглан egazar гар утасны програмд нэвтрэх юм. Нэвтэрснээр тухайн иргэн дараах төрлүүдээр цахимаар хүсэлт гаргах боломжтой болсон. Үүнд:

- Газар ашиглах эрхийн гэрчилгээ сунгах
- Талбайн хэмжээ өөрчлөх
- Нэгж талбарын солбицол өөрчлөх
- Газар ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах
- Өөрийн хүсэлтээр эрхээс татгалзах
- Шүүхийн шийдвэрээр цуцлах/сэргээх
- Бусад өргөдөл




*Зураг 22. Өргөдлийг цахимаар авах*

Цахимаар авах өргөдлийг дотоод систем дээр админ хэрэглэгч тохируулах боломжтой. Ингэснээр нэмж өргөдлийн төрөл оруулах болон өргөдлийн төрлийг хасаг боломжийг бүрдүүлсэн.

Цахимаар авах, авахгүйг тохируулахдаа “Өргөдлийн төрөл” цэсний дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт “Цахим хүсэлтээр авах” гэсэн сонголтыг бөглөөд хадгална.




*Зураг 23. Өргөдлийг цахимаар авах тохиргоо*

## 5.2. Өргөдлийн төрөл тус бүрд шаардлагатай хавсралт оруулах тохиргоо

Хүсэлтийн төрлөөс хамааран оруулах хавсралт материал өөр өөр байна.




*Зураг 24. Хавсралт материал оруулах*

Хавсралтын төрөл болон заавал оруулах эсэхийг тохируулах боломжтой болгосон ба уг хэсгийг мэргэжилтэн админ эрхээр орж тохируулах юм.

Цахимаар авах, авахгүйг тохируулахдаа “Хавсралтын төрөл” цэсний дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт “Цахим хүсэлтээр авах” гэсэн сонголтыг бөглөөд хадгална. Мөн заавал оруулах эсэх тохиргоог уг хэсэгт хийх ба “Анх бүртгэхэд заавал оруулах” сонголтыг сонгож заавал оруулах эсвэл уг хавсралтыг оруулахгүй байх боломжтой эсэхийг тохируулах юм.




*Зураг 25. Хавсралтын төрөл цахимаар авах тохиргоо*

### 5.3. Цахимаар өргөдөл шалгах

Иргэн, аж ахуй нэгж нь цахимаар гаргасан хүсэлтээ гар утасны egazar программаар харах боломжийг бүрдүүлсэн. Өөрийн гаргасан цахимаар гаргасан өргөдлүүдээ харахдаа “Миний өргөдлүүд” цэсийг сонгоно.




*Зураг 26. Миний өргөдөл харагдах хэсэг*

Цахимаар өргөдлүүдээ шалгахдаа “Миний өргөдлүүд” цэсийг сонгоно. Ингэснээр таны гаргасан газрын бүх төрлийн өргөдөл харагдах ба шийдвэрлэгдэж буй явц нь давхар харагдах юм.




*Зураг 27. Өргөдлийн дэлгэрэнгүй мэдээлэл*

Гар утасны egazar программыг ашиглан өөрийн өргөдлөө харахдаа дугаараар хайх боломжтой юм. Өргөдлөө дугаараар хайж дэлгэрэнгүй мэдээллийг харахдаа “Өргөдлийн дугаараар” сонголтыг сонгож дараа нь өргөдлийн дугаарыг оруулан хайж шүүн харах боломжтой.




*Зураг 28. Өргөдөл хайх*

## 5.4. Газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн хувийн хэргийн мэдээллийг системд бүртгэх

ТХГН-т газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн хувийн хэргийг цахимжуулах, системд бүртгэх үйл ажиллагаа нь хоёр янзаар хийгдэнэ.

### 5.4.1. ДАН нэвтрэлтийн системээр дамжуулан бүртгэх

ТХГН-т газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээд нь гар утасны egazar программ болон egazar.gov.mn вэб хуудсаар нэвтрэн орж газрын мэдээлэл харах болон цахим хүсэлт гаргахад ДАН бүртгэлийн системээр дамжих ба амжилттай нэвтэрсэн үед манай систем уг нэвтэрсэн иргэн хуулийн этгээдийг шалган өөрийн системд байхгүй байгаа тохиолдолд автоматаар бүртгэн авах үйл ажиллагааг хийдэг болсон. Ингэснээр ямар нэгэн системийн ажилтан шивж оруулах ажлыг хөнгөвчилсөн.

### 5.4.2. Систем дээр ажилтан бүртгэх

ТХГН-т газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээд нь газар ашиглах хүсэлтийг өөрийн биеэр очиж өгч байгаа тохиолдолд тухайн хүлээн авч буй ажилтан хүсэлт гаргагчийг системд бүртгэлтэй эсэхийг шалган бүртгэлгүй байгаа тохиолдолд гараар бүртгэх боломжтой юм.




*Зураг 29. Иргэн хуулийн этгээд бүртгэх*

## 6. Нэмэлт хөгжүүлэлт

Бид захиалагч талтай удаа дараа уулзалт хийж системийн үйл ажиллагаа болон тулгамдаад буй зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар хуралдсан. Уг уулзалтуудаар гэрээнд заагаагүй бөгөөд зайлшгүй хийгдэх шаардлагатай асуудлууд байсныг бид хийн гүйцэтгэсэн.

### 6.1. Тоон гарын үсгээр нэвтрэх

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргахад egazar.gov.mn цахим хуудсаар дамжуулан гаргаж байгаа билээ. Гэвч нэг асуудал байсан нь уг цахим хуудсанд зөвхөн иргэн нэвтрэх боломжтой байсан ба хуулийн этгээд нэвтрэх боломжгүй байсан. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргаж буй хүсэлт гаргагчдын ихэнх нь хуулийн этгээд байдаг тул бид

хуулийн этгээдийг egazar.gov.mn цахим хуудсанд нэвтрүүлэх үйл ажиллагааг хийн гүйцэтгэсэн.

Газар ашиглах хүсэлт гаргаж буй хуулийн этгээдүүдийг тухайн байгууллагын тоон гарын үсгийг ашиглан нэвтрүүлдэг болгож нэвтрэх хэсэгт хуулийн этгээдээр нэвтрэн товчийг нэмж оруулсан.




*Зураг 30. Хуулийн этгээд нэвтрэх*

Хуулийн этгээдийн тоон гарын үсгээр нэвтрэх хэсэг нь мөн ДАН нэвтрэлт танилтын системээр дамжих юм. Хуулийн этгээдээр нэвтрэхэд зөвхөн тухайн байгууллагыг төлөөлөх ажилтан гар утасны дугаар болон нууц үгээр дамжуулан нэвтрэх боломжтой юм.

Тоон гарын үсгээр нэвтрэхэд ашиглах программ нь emongolia.mn цахим хуудсанд байрлах ба “Тоон гарын үсгийн клиент программ татах” товчийг дарж хүссэн үедээ татах боломжтой.




*Зураг 31. Тоон гарын үсгээр нэвтрэх*

## Ажлын урсгалын тохиргоо

Тусгай хамгаалалттай газрын бүс нутагт шинээр болон бусад шалтгаанаар газар ашиглах хүсэлт гаргасны дараа тухайн хүсэлтийг шийдвэрлэх шат дамжлаг нь маш их, хугацаа маш их ордог бөгөөд хүсэлт гаргаж буй иргэн, аж ахуй нэгжийг маш олон газарлуу материал бүрдүүлэн явуулдгаас болоод хүсэлт гаргагчдад хүндрэлтэй цаашлаад үл ойлголцол бухимдсан тохиолдлууд цөөнгүй гардгийг хэлсэн.

Тусгай хамгаалалттай газрын бүс нутагт газар ашиглах хүсэлт гаргахад Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай газрын захиргаа, Газар

зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газар, Газрын хянан баталгаа үнэлгээний байгууллагууд зэрэг дөрөв буюу түүнээс дээш байгууллагуудтай уулзаж нийтдээ 13-18-н шат дамжлагыг дамждаг. Уг асуудлыг бид захиалагч талтай харилцан ярилцаж тухайн иргэн, аж ахуй нэгжүүдийн дамжиж буй байгууллагуудын үйл ажиллагааг өөрсдийн систем дээр төвлөрүүлэн хүсэлт гаргагч буюу иргэн, аж ахуй нэгжүүдийг нааш цааш гүйлгэхийг болиулж зөвхөн нэг л газар материал бүрдүүлж албан байгууллагууд бүгд нэг зэрэг харж хянаж шийдвэрлэх боломжийг бүрдүүлэн хөгжүүлэхээр болсон.

Тиймээс бид ярилцаж шийдэл хайсны үр дүнд тусгай хамгаалалттай газрын бүс нутагт шинээр болон бусад шалтгаанаар газар ашиглах хүсэлт гаргасны дараагаар тухай хүсэлтийг ямар байгууллагын шат дамжлаг, үйл ажиллагаагаар шийдвэрлэх хэсгийг ажлын урсгалын тохиргоо модулиар шийдсэн.

Уг модулийн зорилго нь тухайн шийдвэрлэх шатны дараагаар ямар шатруу орохыг заан системийг хэрэглэж буй ажилтанд хөтөч болох юм.

### 6.1.1. Ажлын урсгалыг төлөв

Ажлын урсгалын төлөв гэдэг нь тухайн иргэн аж ахуй нэгжийн гаргасан хүсэлт ямар шат дамжлагаар дамжиж шийдвэрлэгдэж байгааг илэрхийлэх товчилсон нэршил юм. Жишээ нь иргэн, аж ахуй нэгж газар ашиглах хүсэлтээ дөнгөж гаргасан байгаа тохиолдолд “Шинээр хүсэлт гаргасан” гэх мэт. Уг товчилсон нэршлийг захиалагч тал тодорхойлох ба өөрчилж засварлах боломжтой юм.

| | code [PK] integer | description character varying(75) | description_en character varying(75) |
|---|---|---|---|
| 1 | 1 | 1: Өргөдөл хүлээн авч бүртгэсэн | 1: Registered |
| 2 | 2 | 2: Суурин судалгаа хийх | 2: Returned from pre-meeting |
| 3 | 3 | 3: Хээрийн судалгаа хийх | 3: Field survey done |
| 4 | 4 | 4: Кадастрийн зурагт шинэчлэл хийх | 4: Update of cadastre map done |
| 5 | 5 | 5: Засаг даргын захирамжийн төсөлд оруулах | 5: Waiting to be sent to governor |
| 6 | 6 | 6: Засаг даргын захирамжийн төсөлд явуулах | 6: Sent to governor for decision |
| 7 | 7 | 7: Засаг даргын захирамж / Нотариат бүртгэх | 7: Approved by governor |
| 8 | 8 | 8: Засаг даргын захирамжийн хариу мэдэгдэх / Шийдвэрлэх боломжгүй | 8: Refused by governor |
| 9 | 9 | 9: Гэрээ байгуулж гэрчилгээ олгох / Өмчлөлийн бүртгэл | 9: Finalized |
| 10 | 10 | 10: Улсын Бүртгэл руу илгээсэн | 10: Sent to GASR |
| 11 | 11 | 11: Улсын Бүртгэл зөвшөөрч дугаар олгосон | 11: Approved by GASR and issued number |
| 12 | 12 | 12: Улсын Бүртгэл татгалзсан | 12: Refused by GASR |
| 13 | 13 | 13:Барьцаанд бүртгэх | 9:Mortgage |
| 14 | 14 | 14: Хурлаар оруулах | 14: Meeting |

*Зураг 32. Ажлын урсгалын төлөв*

### 6.1.2. Ажлын урсгал

Ажлын урсгал модуль нь ажлын урсгалын төлөвүүдийг ашиглан газар ашиглах хүсэлтийг шийдвэрлэх үйл явцын дарааллыг тохируулах юм. Жишээ нь “Өргөдөл хүлээн авсан” гэсэн явцын дараагаар материал бүрдүүлэлт дутуу гэх үндэслэлээр буцаах бол “Бүрдүүлэх материал дутуу” гэсэн төлөвийг сонгож буцаах эсвэл ямар нэгэн асуудалгүй үед “Суурь судалгаа хийх” гэх мэт төлөвийг сонгох боломжтой юм. Эдгээр явцуудын сонголт нь нэг явцаас тухайн бүрдүүлсэн материалаас хамааран шийдвэрлэх боломжтой үгүйг харгалзан хийгдсэн тохиргооны дагуу хэдэн ч өөр төлөвт шилжих боломжтой. Энэ нь өргөдөл буюу газар ашиглах хүсэлт хүлээн авсны дараа буцаах эсвэл хүлээн авч цааш шийдвэрлэх гэсэн сонголтыг сонгуулахаар тохируулах боломжтой гэсэн үг юм. Тухайн явцаас хамааран дараагийн сонгох боломжит явц нь харилцан адилгүй буюу шилжих явцын тоо өөр өөр байх боломжтой.

Ажлын урсгал нь иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн хүсэлтийн төрлөөс хамааран үйл ажиллагаа нь ялгаатай байна.




*Зураг 33. Ажлын урсгал*

Ажлын урсгалын дэлгэрэнгүй хэсэг нь

- Ерөнхий мэдээлэл
- Төлөв
- Өргөдлийн төрөл гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.

**Ерөнхий мэдээлэл**

Ерөнхий мэдээлэл хэсэгт тухайн ажлын урсгалын нэр, код болон тухайн ажлын урсгалын төрлийг тайлбарласан дэлгэрэнгүй тайлбар хэсгээс бүрдэх мэдээллүүд харагдах ба мэдээллийг засварлах боломжтой.




*Зураг 34. Ажлын урсгалын ерөнхий мэдээлэл*

## Төлөв

Төлөв хэсэгт тухайн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааны дараалал буюу явцуудыг тохируулах үйл ажиллагаа хийгдэнэ.




*Зураг 35. Ажлын урсгалын төлөв*

Ажлын урсгалыг шинээр нэмэх хэсэг нь одоогийн байгаа төлөвийн төрөл ба дараагийн шилжих боломжтой төлөвийн төрлийг сонгох гэсэн хэсгээс бүрдэнэ. Нэг төлөвөөс хэдэн ч өөр төлөврүү шилжих тохиргоо хийх боломжтой юм.




*Зураг 36. Ажлын урсгалын төлөв нэмэх*

**Өргөдлийн төрөл**

Өргөдлийн төрөл хэсэг нь тухайн ажлын урсгалын төрлөөр шийдвэрлэгдэх хүсэлтийн төрлүүдийг тохируулдаг хэсэг юм.

Өргөдлийн төрөл нь тухайн ажлын урсгалаар явах боломжтой бол хэдэн ч төрөл багтаж болох юм. Тухайлбал шинээр газар ашиглах хүсэлт болон хугацаа сунгах хүсэлтийн шийдвэрлэх үйл ажиллагаа нь ижил шат дамжлагаар дамжиж шийдвэрлэгддэг бол өргөдлийн төрөл хэсэгт тусгай хамгаалалттай газар нутагт шинээр ашиглах өргөдөл болон хугацаа сунгах өргөдлийн төрлийг хамт сонгож өгч уг ажлын урсгалаар шийдвэрлэх боломжтой гэсэн үг юм.




*Зураг 37. Ажлын урсгалын өргөдөл*

Админ хэрэглэгчийн тохируулсан ажлын урсгалын дагуу шийдвэрлэгдэж байгаа өргөдлийн явц буюу үйл ажиллагааны дараалал мөн одоо ямар шийдвэрлэх явцад байгаа нь дараах байдлаар харагдана.




*Зураг 38. Ажлын урсгалын дагуу шийдвэрлэгдэж буй өргөдөл*

## 6.2. Улсын тэмдэгтийн хураамжийн модуль

Тусгай хамгаалалттай газар нутагт газар шинээр ашиглах болон хугацаа сунгах, талбай хэмжээ өөрчлөх зэрэг хүсэлтийн дагуу өргөдөл үүсгэхэд тухайн хүсэлтийн төрлөөс хамаарч улсын тэмдэгтийн хураамж авдаг. Бид энэхүү тэмдэгтийн хураамжийг өргөдлийн төрлөөс хамааран өөр өөр байж болохоор тохиргооны модулийг хийж гүйцэтгэлээ.

### 6.2.1. Улсын тэмдэгтийн хураамжийн бүртгэл /Үйлчилгээний төрөл/

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах болон хугацаа сунгах, талбай хэмжээ өөрчлөх өргөдөл үүсгэхэд тухайн хүсэлтийн төрөлд хамааруулан тэмдэгтийн хураамжийн үнэлгээг тохируулж бүртгэх модуль юм.

Үйлчилгээний төрөл модуль хэсэгт улсын тэмдэгтийн хураамжаас гадна үйлчилгээний төлбөрийн хураамжийг нэмэх боломжтой ба цаашлаад хийгдэж буй үйл ажиллагаанаас хамааран төлбөр хураамж авах төрөл нэмэгдэх боломжтой юм.




*Зураг 39. Үйлчилгээний төрөл*

**Үйлчилгээний төрөл нэмэх**

Үйлчилгээний төрлийг нэмэхэд бид үйл ажиллагаанд тохируулан иргэн болон аж ахуй нэгжийн хураамж гэж ялгасан ба мөн үйлчилгээ авч буй газрын байршлаас хамааран үйлчилгээний өртөг болон хураамжийн үнэ харилцан адилгүй байдгийг тооцон иргэн, аж ахуй нэгж дотроо Улаанбаатар, аймгийн төвийн сум, бусад сум гэсэн үнийн мэдээллийн хэсгүүдийг нэмж оруулах боломжтойгоор хийсэн.




*Зураг 40. Үйлчилгээний төрөл нэмэх*

Нэмэгдсэн үйлчилгээний төрлүүдийг засварлах болон буруу үүсгэсэн тохиолдолд устгах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр тухайн байгууллагад хураамжийн үнэд өөрчлөлт өрсөн тохиолдолд үйлчилгээний төрөлрүү орж шинэчилсэн хураамжийн дүнгээр солих боломжтой юм.

### 6.2.2. Өргөдөлд тэмдэгтийн хураамж холбох

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргасны дагуу тухайн хүсэлтийн төрлөөс хамааран өргөдөл үүснэ. Уг үүссэн өргөдлийн дэлгэрэнгүй мэдээллийн хэсэгт “Хураамж” хэсэг багтах ба хураамж хэсэгт тухайн өргөдөлтэй хамаарал бүхий хураамжийн төрлөөс хамааран хураамжийн мэдээллийг нэмж оруулна.




*Зураг 41. Үйлчилгээний хураамж нэмэх*

Үйл ажиллагааны төрлөөс хамааран үйлчилгээний төрөлд бүртгэлтэй үйлчилгээний төрлүүдээс сонгон өргөдөлд төлбөрийн мэдээллийг нэмж оруулсны дараагаар төлөх ёстой үйлчилгээний болон улсын тэмдэгтийн хураамжийн жагсаалт дараах байдалтайгаар харагдана.




*Зураг 42. Үйлчилгээний хураамжийн жагсаалт*

## 6.3. Цахимаар хавсралт хэвлэх

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах хүсэлт гаргахад заавал шаардагдах хавсралтууд байдаг ба эдгээр хавсралтуудыг иргэн, аж ахуй нэгж гадуур хөөцөлдөж, цуглуулах гэж маш их цаг зарцуулж байгаа. Энэ асуудлыг хөнгөвчлөх зорилгоор бид захиалагч талтай харилцан ярилцаж системээс гаргаж чадах хавсралтуудыг иргэнд цахимаар хүргэж хүсэлт гаргагчдын цагийг бага ч гэсэн хэмнэхээр ажиллалаа.

### 6.3.1. Ашиглаж буй газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт хэвлэх

Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт нь тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж буй газрын хугацаа болон талбай сунгах зэрэг хүсэлтүүдийг гаргахад шаардагддаг хавсралт материал юм. Газрын тооцоо нийлсэн актыг газрын албанаас авахад оочир дарааллаас эхлээд газрын алба байршдаг аймаг, сумдаас хол байх зэрэг олон асуудлууд тулгарч байгаа юм. Тиймээс тухайн газар ашиглагч нь монгол улсын харьяалалтай тохиолдолд өөрийн нэр дээр бүртгэлтэй газрын тооцоо нийлсэн актыг egazar.gov.mn цахим хуудсаар өөрөө хэвлэж авах боломжийг бид бүрдүүлсэн.




*Зураг 43. Тооцоо нийлсэн акт хэвлэх*

### 6.3.2. Ашиглаж буй газрын хянан баталгааны мэдэгдэх хуудас хэвлэх

Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж буй газрын хугацаа болон талбай сунгах зэрэг хүсэлтүүдийг гаргахад хянан баталгааны дүгнэлтийг шаарддаг. Хянан баталгааны дүгнэлтийг хийлгэхэд тухайн газар ашиглагч нь газрын хянан баталгаа хийлгэх хүсэлт буюу мэдэгдэх хуудсыг авах шаардлагатай байдаг ба уг мэдэгдэх хуудсыг газрын албанаас авахын тулд цаг хугацаа алддаг байдлыг болиулж egazar.gov.mn цахим хуудсаар өөрөө хэвлэж авах боломжийг бид бүрдүүлсэн.




*Зураг 44. Мэдэгдэх хуудас*

### 6.3.3. Ашиглаж буй газрын хянан баталгааны дүгнэлт хэвлэх

Тусгай хамгаалалттай газар нутагт ашиглаж буй газрын хугацаа болон талбай сунгах зэрэг хүсэлтүүдийг гаргахад хянан баталгааны дүгнэлтийг шаарддаг. Хянан баталгааны дүгнэлт нь цахим хэлбэрт шилжсэн ба дүгнэлтийн бүх мэдээлэл газрын системд байдаг тул системээс дүгнэлтийг хэвлэж авах боломжтой байдаг.

Газар ашиглагч нь ашиглаж буй газар дээрээ хийлгэсэн хянан баталгааны дүгнэлт хянан баталгаа хийгдсэн оноороо жагсаж харагдах ба шаардлагатай хянан баталгааны дүгнэлтийн мэдээллийг egazar.gov.mn цахим хуудсаар өөрөө хэвлэж авах боломжийг бид бүрдүүлсэн.




*Зураг 45. Дүгнэлт хэвлэх*